



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/1148

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөө дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, арчлалт хамгаалалт, орчны тохижилтын ажил болон усан оргилууруудыг сэргээн засварлах, тохижуулах ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.


2. Дээрх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор байгуулсугай.

3. Сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Г. ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
... 2019 оны ... 05 ... сарын 24 өдрийн
... А/148 тушаалын ... 2 ... хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Билгүүн	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10-р хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 08 сарын 24 өдрийн
тушварын хавсралт



ХӨШӨӨ ДУРСГАЛТ ЗҮЙЛСИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, АРЧЛАЛТ ХАМГААЛАЛТ ОРЧНЫ
ТОХИЖИЛТЫН АЖИЛ БОЛОН УСАН ОРГИЛУУРУУДЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, ТОХИЖУУЛАХ
АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Тоо хэмжээ /байршил/	2019 онд санхүүжих /сая төгрөг/
1.	ХУД, 11 дүгээр хороо, Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын хөшөөт цогцолбор, СБД, 6 дугаар хороо, Сүхбаатарын хөшөө орчмын чулуун шалыг сэргээн засварлах ажил	2	50.0
2.	БЗД-ийн 13 дугаар хороо, Эскадрилийн усан оргилуурт хөшөө цогцолборыг сэргээн засварлаж тохижуулах ажил	1	50.0
	Дүн	3	100.0